

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

2021 оны 05-р сарын 25 ны өдөр

Mongol Music дуу хөгжим түгээх үйлчилгээний www.mongolmusic.mn сайт-д /цаашид Сайт гэх/ тавтай морилно уу. Энэхүү Үйлчилгээний нөхцөл /цаашид “Үйлчилгээний нөхцөл” гэх/ нь Сайтыг ашиглахтай холбоотой нөхцөл, журмыг тодорхойлно.

Уран бүтээлч, эрх эзэмшигч нь Mongol Music Distribution үйлчилгээг “Дуу хөгжим түгээх үйлчилгээний Гэрээ” гэрээ байгуулан ашигладаг бөгөөд гэрээний дижитал хуулбарыг эндээс харах боломжтой. /линк оруулах/

Тан Сайт-д нэвтэрч, үйлчилгээг ашигласнаар энэхүү үйлчилгээний нөхцөлийг зөвшөөрч байна гэж үзэх тул та үйлчилгээний нөхцөлийг мөрдөн биелүүлэх үүрэг хүлээнэ.

Mongol Music нь (цаашид Монгол Контент ХХК, Монгол Контент, Бид, Манай гэх) энэхүү Үйлчилгээний нөхцөлд хэдийд ч хэсэгчлэн болон бүхэлд нь өөрчлөлт оруулах, засварлах, нөхцөл нэмэх болон хасах эрхтэй байна.

Хэрэв бид өөрчлөлт оруулсан тохиолдолд Үйлчилгээний нөхцөлийн шинэчилсэн хувилбарыг сайт дээрээ байршуулж, Таньд мэдэгдэх болно.

Ийнхүү үйлчилгээний нөхцөл шинэчлэгдсэн өдрөөс хойш та үйлчилгээг ашиглах нь мөн үйлчилгээний шинэчлэгдсэн нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно.

1. Сайтыг ашиглагч нь Монгол Улсын холбогдох хуулийн дагуу эсхүл тухайн харьяа улсынхаа хуулийн дагуу өөртөө эрх олж авах болон зохих үүргийг бий болгох чадвартай 18 насанд хүрсэн иргэн байна. Хэрэв Та аливаа компани, хуулийн этгээд эсвэл байгууллага (хамтад нь “Байгууллага” гэх)-ын өмнөөс Үйлчилгээг ашиглах бол Та тухайн Байгууллагын эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд түүнийг төлөөлөн энэхүү Үйлчилгээний ерөнхий нөхцөлийг дагаж мөрдүүлэхээ мэдэгдэж, баталгаа гаргаж байгаа болно.
2. Үйлчилгээний Нөхцөл болон холбогдох хууль тогтоомж : Та Сайт-ыг ашиглахдаа Үйлчилгээний Нөхцөл болон холбогдох гэрээ, хууль, журам, дүрмийг дагаж мөрдөх ёстой.
3. Оюуны өмч: Бид сайт болон түүнд агуулагдаж байгаа бусад агуулгатай холбоотой зохиогчийн эрх, патент зэрэг оюуны өмчийг ашиглах эрхийг эзэмшдэг болно. а. Сайт-д байрлуулсан барааны тэмдэг, лого, үйлчилгээний тэмдэг нь бидний болон манай харилцагчидийн эзэмшилд байна. b. Энэ хэсгийн а) заалт нь таны оюуны өмчийн эрхэд хамаарахгүй болно. Таны сайт-д байршуулсан бүтээлтэй холбоотой бүх эрхийг Үйлчилгээний гэрээнд тусгасан болно.
4. Хориглох зүйлс. Бидний шүүд зөвшөөрөлгүй дараах зүйлсийг хийхийг хориглоно
 - a. Програм хангамж, техник хангамжийг тасалдуулах, гэмтээх зориулалттай вирус болон бусад програм, технологийг ашиглан сайтын үйл ажиллагаанд саад учруулах;
 - b. Төрөл бүрийн спам тараах
 - c. Хэрэглэгч болон холбогдох этгээдийн зөвшөөрөлгүйгээр тэдгээрийн хувийн мэдээллийг цуглуулах, цуглуулахыг оролдох;
 - d. Аливаа хувь хүн, хуулийн этгээдийн нэрийг хуурамчаар ашиглах, харилцаа хамаарлыг худал мэдээлэх, зөвшөөрөлгүйгээр бусдын эрхээр нэвтрэх, мэдээллийг хуурамчаар үйлдэх,

- e. Сайтын нэр эсвэл барааны тэмдэг болон ажилтнуудын нэрийг барьж хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулах,
 - f. Сайтын эх кодын бүтцийг хуулбарлах, шинжлэх, түүнээс эх код бүтээх, задлах, эвдэх болон гагцхүү энэ төрлийн үйл ажиллагаа явуулахыг тусгайлан заасан холбогдох хуулийн зөвшөөрлөөс бусад тохиолдолд Сайтын эх код болон түүний бүрдэл хэсгийг илчлэх, илчлэхийг завдах;
 - g. Хууль бус зорилгоор ашиглах эсвэл улс, бүс нутаг, үндэсний болон олон улсын хууль, ялангуяа оюуны өмч, өмчийн бусад эрх, дата хамгаалалт, нүүцлалтай холбоотой хууль тогтоомж зэргийг зөрчихөд ашиглах
 - h. Хориглосон аливаа үйл ажиллагаанд оролцоход хөндлөнгийн гуравдагч этгээдэд түслах
 - i. Зохиогч, зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийн энэ хуульд заасан эрхийг хэрэгжүүлэх, өөрийн бүтээл, хамаарах эрхийн объектыг зөвшөөрөлгүйгээр ашиглахаас урьдчилан хамгаалах зорилгоор хэрэглэж байгаа технологийн хамгаалалтыг санаатайгаар эвдэх, идэвхгүйжүүлэх, устгах, гэмтээхийг хориглох бөгөөд эдгээр үйлдлийг зохиогчийн эрх, эсхүл хамаарах эрхийн зөрчилд тооцно.
5. Сайтыг өөрчлөх. Бид сайтын агуулга болон хэлбэрийг өөрийн үзэмжээр өөрчлөх боломжтой.
6. Байнгын үйл ажиллагаа. Монгол контент нь Сайтын болон Mongol Music үйлчилгээний байнгын тасралтгүй үйл ажиллагааг ханган ажилладаг хэдий ч дараах асуудлаар баталгаа гаргахгүй. Үүнд:
- a. зарим нэг техникийн хүндрэл, засвар үйлчилгээ зэргээс шалтгаалж түр зуур тасалдах,
 - b. зарим алдаа, доголдол гарах,
 - c. таны хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байх,
 - d. таны ашигладаг програм болон техник хангамжтай зохицон ажиллах боломжгүй байх болон бусад.
7. Хариуцлага. Хэрэв та энэхүү үйлчилгээний нөхцөлийг зөрчсөн тохиолдолд, Монгол Контент нь таны энэ үйлчилгээг ашиглах эрхийг хориглох, хязгаарлах болон таны эсрэг хуулийн дагуу арга хэмжээ авах бүрэн эрхтэй байна.
8. Мэдээлэл хүргүүлэх. Үйлчилгээний нөхцөл, журамтай холбоотой асуулт, санал хүсэлт байвал та доорхи хаягаар хандана уу.